



**“ГОВЬ-ЭРДЭНЭ” ЖУУЛЧНЫ БААЗЫН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН  
/2025 ОН/**

**Тайлан боловсруулсан:**

“Олгүүд” ХХК-ийн гүйцэтгэх захирал

/ А. БОЛД-ЭРДЭНЭ /

Улаанбаатар хот  
2025 он

“Говь-Эрдэнэ” жуулчны баазын товч танилцуулга

“Оллгүүд” ХХК-ийн харьяа “Говь-Эрдэнэ” жуулчны бааз нь 2012 онд байгуулагдсан бөгөөд Өмнөговь аймгийн Сэврэй сумын нутагт үйл ажиллагаагаа явуулж байна. Манай жуулчны бааз нь Говь Гурван Сайханы Байгалийн Цогцолборт Газарт орших Хонгорын их элсэн манханг үзэж сонирхохоор ирсэн жуулчид, зочидыг хүлээн авч үйлчилдэг.

“Говь-Эрдэнэ” жуулчны баазын хүчин чадал:

- Нийт 75 ор бүхий 30 ширхэг монгол гэр
- Нийт 24 ор бүхий 12 ширхэг модон байшин
- Нэг удаад 100 хүртэл хүн хүлээн авч үйлчилэх хүчин чадалтай ресторан
- Ариун цэврийн байгууламж – эрэгтэй, эмэгтэй тус бүр нь 6 ширхэг угаалтуур, душ, суултууртай.

Жуулчны баазын ажилчдын орон тоо 25-35 хүртэл байдаг бөгөөд ажилчидын 85% нь Өмнөговь аймгийн орон нутгийн иргэд байдаг.

### **2025 оны үйл ажиллагааны төлөв**

Бид 2025 оны 5 сараас жуулчны баазын бэлтгэл ажлыг хангаж, 6-р сараас үйл ажиллагаагаа нээн жуулчид, амрагчдыг хүлээн авч үйлчилсэн бөгөөд 9-р сарыг дуустал нээлттэй ажилласан болно.

2025 оны хувьд мод тарих төлөвлөгөөний дагуу Өмнөговь аймгийн мод үржүүлэгийн газраас 100 ширхэг хайлаас модыг хүлээн авч 5-р сард жуулчны баазын хашаанд тарьж суулгасан. 9-р сард 30 ширхэг хайлаас, 30 ширхэг жигд, 40 ширхэг гүйлс мод худалдан авч жуулчны баазын хашаандаа суулгасан.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд сум орон нутгуудад мод тарьж ургуулах ажлын дагуу 2025 оны 6 сард Сэврэй сумын Сайншанд баг, Хонгорын элсний Сэрүүн булагийн хөвөөнд 1.500 ширхэг бургас болон 108 жигд мод тарих ажил зохион байгуулагдсан. Уг ажилд Сэврэй сумын ЗДТГ, сумын ерөнхий боловсролын дунд сургууль, сумын эмнэлэг, Хонгорын голын хөгжил ТББ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагын ажилчид албан хаагчид оролцсон бөгөөд манай жуулчны баазын удирдлага ажилчид идэвхитэй оролцон мод тарилцлаа.


2025 оны газар ашигласны төлбөр болох нийт 1.800.000,- төгрөгийг Сэврэй сумын татварын дансанд төвлөрүүлсэн. Сэврэй сумын ЗДТГ-ын зөвлөмж, зааврын дагуу хог хаягдлыг сумын захиргаанаас тогтоосон нэгдсэн цэгт аваачиж буулгаж байгаа бөгөөд 120.000,- төгрөгийн хог хаягдын хураамжийг орон нутагт төлсөн.

Өмнөговь аймгийн Байгаль орчны газраас ус ашиглах дүгнэлт гаргуулан Сэврэй суманд 807.581,80 төгрөгийг ус ашигласны төлбөрт төлсөн.

№	2025 онд хийгдсэн ажлууд	Үр дүн	Зардал болон тайлбар
1	Жуулчны баазын хашаанд тарьж ургуулж буй мод бутыг тогтмол усалж, арчилах	Хөрс, ургамлын нөмрөг гэмтэх зэрэг экологийн тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх	Мод усалгааны системээр тогтмол усалж, арчилж тордсон
2	Газар ашиглалтын гэрээг харьяа засаг захиргааны байгууллагатай хийж баталгаажуулах, төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах	Орон нутгийн хөгжлийг дэмжих, байгаль орчинг нөхөн сэргээхэд ашиглах хөрөнгийн эх үүсвэртэй болгоход чиглэгдэнэ.	1.280.660,- төгрөг /2025 онд сум орон нутагт газар ашигласны төлбөр болгон төлсөн/
3	Өмнөговь аймгийн Байгаль орчны газраас ус ашиглах дүгнэлт гаргуулан Сэврэй суманд ус ашигласны төлбөр төлсөн	Төслийн талбайг бохирдлоос сэргийлэх	807.581,80 төгрөг
4	Усны ерөнхий шинжилгээ		65.000,- төгрөг Жуулчны баазын ашиглаж буй гүний худагнаас дээж аван Улаабаатар хотод Гео экологийн хүрээлэнгийн Лабораторид шинжлүүлсэн
5	Сум орон нутгийн захиргаатай хамтран хогийн нэгдсэн цэг байгуулах	Хатуу хог хаягдал ил задгай хаягдахаас сэргийлэх	120.000,- төгрөг
6	Хог хаягдыг ангилан хаях сав хийсэн. Хуванцар, шил, төмрийн хаягдал ангилан цуглуулна.		100.000,- төгрөг
7	Жуулчны баазын хашаанд мод тарьсан.	Ашиглаж буй газартаа ногоон байгууламж бий болгосон.	130 ширхэг хайлаас, 30 ширхэг жигд, 40 ширхэг гүйлс модны суулгац тарьсан
8	Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд 2025 оны 6 сард Сэврэй сумын Сайншанд баг, Хонгорын элсний Сэрүүн булагийн хөвөөнд мод тарих ажилд идэвхитэй оролцсон.	1500 ширхэг бургас мод тарьж суулгасан.	Сэврэй сумын ЗДТГ, сумын эмнэлэг, сургууль, Хонгорын голын хөгжил ТББ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагын ажилчид албан хаагчидтай хамтран тарилцсан.

9	Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг орн нутгийн төрийн бус байгууллагуудыг дэмжих, хамтран ажиллах	ТББ-ыг дэмжих, орон нутагт байгаль орчны үйл ажиллагааг идэвхитэй явуулахад туслалцаа үзүүлэх	Сэврэй сумын Хонгорын голын хөгжил ТББ-д 2025 онд 5.000.000,- төгрөгийн хандив өгсөн.
---	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------





„Говь-Эрдэнэ“ баазын ерөнхий дотоод зохион байгуулалт





Жуулчдын амрах дүнзэн байшин



Жуулчны баазын ресторан





Жуулчдын амрах гэрийн доторх байдал





## МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1250201106598

ТТД / Регистр:	18001133117 / 5265134
Татвар төлөгчийн нэр:	Оллгүүд
Татварын төрөл:	01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Харьяалах татварын алба:	Өмнөговь / Сэврэй
Төлсөн дүн:	448,170.00 ₮
Гүйлгээний огноо:	2025-02-20 20:55:04.0
Гүйлгээний утга:	1250201106598;5265134;;;88115701;1103041872;ОЛЛГҮҮД ХХ;Golombank-Online;88115701
Татварын данс:	Өм.Сэ Газрын төлбөр - 100110900943
Төлөлтийн хэлбэр:	Голомт банк





## МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1250201095619

ТТД / Регистр: 18001133117 / 5265134  
Татвар төлөгчийн нэр: Оллгүүд  
Татварын төрөл: 01030731 - Газрын төлбөр-Дэд алба  
Харьяалах татварын алба: Өмнөговь / Сэврэй  
Төлсөн дүн: 448,170.00 ₮  
Гүйлгээний огноо: 2025-02-20 20:54:37.0  
Гүйлгээний утга: 1250201095619;;5265134;;;88115701;1103041872;ОЛЛГҮҮД ХХ;Golomtbank-Online;88115701  
Татварын данс: Өм.Сэ Газрын төлбөр - 100110900943  
Төлөлтийн хэлбэр: Голомт банк



## МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1250201116787

ТТД / Регистр: 18001133117 / 5265134  
Татвар төлөгчийн нэр: Оллгүүд  
Татварын төрөл: 01030731 - Газрын төлбөр-Дэд алба  
Харьяалах татварын алба: Өмнөговь / Сэврэй  
Төлсөн дүн: 384,320.00 ₮  
Гүйлгээний огноо: 2025-02-20 20:55:41.0  
Гүйлгээний утга: 1250201116787;;5265134;;;88115701;1103041872;ОЛЛГҮҮД ХХ;Golomtbank-Online;88115701  
Татварын данс: Өм.Сэ Газрын төлбөр - 100110900943  
Төлөлтийн хэлбэр: Голомт банк



	<h2>МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА</h2>
	TATBAP ТӨЛСӨН БАРИМТ № - 225101017306
ТТД / Регистр:	17900832832 / 9048146
Татвар төлөгчийн нэр:	Өмнөговь аймгийн Сэврэй сумын Засаг даргын тамгын газар
Татварын төрөл:	01030708 - Ахуйн хэрэглээний ус, рашаан ашигласны төлбөр
Харьяалах татварын алба:	Өмнөговь / Сэврэй
Төлсөн дүн:	807,581.80 ₮
Гүйлгээний огноо:	2025-11-10 18:21:48
Гүйлгээний утга:	225101017306;;5265134;;88115701;1103041872;ОЛЛГҮҮД ХХ;Golomtbank-Online;88115701
Татварын данс:	Өм.Сэ Ус, рашааны төлбөр - 10010900944
Төлөлтийн хэлбэр:	Голомт банк
	

	<h2>МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА</h2>
	TATBAP ТӨЛСӨН БАРИМТ № - 2250902141117
ТТД / Регистр:	45000850192 / 2875101
Татвар төлөгчийн нэр:	Дэмд-Од
Татварын төрөл:	01030723 - Хог хаягдлын үйлчилгээний хураамж
Харьяалах татварын алба:	Өмнөговь / Сэврэй
Төлсөн дүн:	120,000.00 ₮
Гүйлгээний огноо:	2025-10-01 16:41:05
Гүйлгээний утга:	2250902141117;;5265134;;88115701;1103041872;ОЛЛГҮҮД ХХ;Golomtbank-Online;88115701
Татварын данс:	Өм.Сэ Хог хаягдлын хураамж - 10010900947
Төлөлтийн хэлбэр:	Голомт банк
	

























